

Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл,
машин тоног төхөөрөмжийн түүвэр

НОГООН БАЙГУУЛАМЖ

Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл,
машин тоног төхөөрөмжийн түүвэр



ГАРЧИГ

1	Зорилго.....	5
2	Хамрах хүрээ.....	5
3	Норматив эшлэл	5
4	Нэр томьёоны тайлбар.....	6
5	Цэцэрлэгжүүлэлтийн багаж хэрэгслийн ангилал.....	6
5.1	Цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл.	7
5.2	Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд.....	10
5.3	Зүлэгжүүлэлтийн ажилд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүд.....	12
5.4	Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл.....	15
5.5	Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	19
5.6	Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	21
5.7	Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	22
5.8	Хот тохижилтын цэвэрлэгээ арчилгаанд ашиглагдах багаж	26
5.9	Мод, сөөгийн хэлбэржүүлэлтэнд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	28
5.10	Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	31
5.11	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм.....	33
5.12	Ногоон байгууламжийн өвчин хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл.....	35
6	Цэцэрлэгчийн багаж тоног төхөөрөмжийн шаардлага.....	37
	Ашигласан хэвлэлийн жагсаалт.....	38

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 5.1 Цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл..	7
Хүснэгт 5.2 Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд.....	10
Хүснэгт 5.3 Зүлэгжүүлэлтийн ажилд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	13
Хүснэгт 5.4 Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл.....	15
Хүснэгт 5.5 Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	19
Хүснэгт 5.6 Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	21
Хүснэгт 5.7 Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	22
Хүснэгт 5.8 Хот тохижилтын цэвэрлэгээ үйлчилгээнд ашиглагдах багаж.....	26
Хүснэгт 5.9 Мод, бут сөөгийн хэлбэржүүлэлтэд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	28
Хүснэгт 5.10 Мод, бут сөөгийн шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	31
Хүснэгт 5.11 Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм.....	33
Хүснэгт 5.12 Ногоон байгууламжийн өвчин хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл.....	35
Хүснэгт 6.1 Цэцэрлэгчийн багаж тоног төхөөрөмжийн шаардлага.....	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 6.1 Талбайн хөрс боловсруулалт.....	12
Зураг 6.2 Үрийг гараар нэгэн жигд цацах.....	18
Зураг 6.3 Үрийг механизмаар цацах.....	18
Зураг 6.4 Зүлгийн тайралт, арчилгаа.....	18
Зураг 6.5 Цэцэрлэгжүүлсэн талбайн навчийг цэвэрлэх.....	28
Зураг 6.6 Мод, сөөгийг хэлбэржүүлэх	31

НОГООН БАЙГУУЛАМЖ

Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн түүвэр

1. ЗОРИЛГО

Энэхүү эмхэтгэлийн зорилго нь ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, албан байгууллагуудын цэцэрлэгчийн тохижилт цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах хөдөлмөрийн чухал шаардлагатай багаж хэрэгсэл, машин, тоног төхөөрөмжийн түүврийг боловсруулахад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү эмхэтгэлийг цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, хот тохижилт, гудамж, зам талбайг тохижуулах зорилгоор иргэн, аж ахуй нэгж, эрх бүхий байгууллагуудад хэрэглэнэ.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Эмхэтгэлд олон улсын болон Монгол улсын хэмжээнд баримталж буй стандарт, техникийн шаардлагад суурилсан бөгөөд тухайн стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эх материалыг баримтална.

MNS 6139:2010 Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.

MNS 6141:2010 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.

MNS 2418:2011 Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах. Ерөнхий шаардлага.

MNS 6253-1:2011 Мод сөөгийн үрийг тарихад бэлтгэх- Ерөнхий шаардлага

MNS 6253-2:2011 Мод сөөгийн үр тарих. Ерөнхий шаардлага

MNS 6253:2011 Мод сөөгийн үр тарьсны дараа арчлах -Ерөнхий шаардлага

MNS 6254:2011 Мод сөөгийн суулгацыг бойжуулах -Ерөнхий шаардлага

MNS 6256:2011 Сөөгөнцрийн суулгац- Ерөнхий шаардлага

MNS 6257:2011 Улиасны суулгац -Ерөнхий шаардлага

MNS 6258-1:2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах.- Ерөнхий шаардлага

MNS 6258-2:2011 Мод сөөгийн суулгац арчлах

MNS 6259:2011 Ганц наст цэцэг тарих арга

MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах

MNS 6772:2019 Мод сөөгийг хэлбэржүүлэх - Техникийн шаардлага

MNS 6773:2019 Сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах -Техникийн шаардлага

MNS 6774:2019 Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах

4. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Суулгац - гэж бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаж ургуулсан 2-оос дээш настай модлог ургамал;

Мод - гэж титэм бүхий гол иштэй модлог ургамал;

Сөөг - гэж гол ишгүй, үндэсний хүзүүнээс дээш адил хэмжээний олон иштэй, 5 м хүртэл өндөр ургадаг модлог ургамал;

Мөчир - гэж навч, шилмүүс бүхий салаалсан иш;

Тайралт - гэж мод, сөөгийн титмийн жигд өсөлтийг дэмжих арчилгаа юм. Мод, сөөгийн титмийн жигд өсөлт, гадаад үзэмжийг харгалзан хавар эрт, намар орой титмийг хэлбэржүүлэх, цэвэрлэх, залуужуулах тайралт хийнэ;

Огтлолт - гэж мод, сөөгийн титмийн хэсэгт хийх арчилгаа юм;

Ажлын тусгай хувцас - гэж гаднын нэг болон хэд хэдэн хүчин зүйл, тааламжгүй сөрөг нөлөөллөөс хамгаалах зорилгоор тусгайлан хийсэн хувцас;

Багаж хэрэгсэл - гэж ногоон байгууламжийн ургамлыг арчлах, хамгаалах үйл ажиллагаанд ашиглах тусгай зориулалт бүхий хэрэгсэл;

5. ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, албан байгууллагуудын цэцэрлэгчийн тохижилт цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах хөдөлмөрийн чухал шаардлагатай багаж хэрэгсэл, машин, тоног төхөөрөмжийг ерөнхий ашиглалт, зориулалтаар нь дараах байдлаар ангилсан. Үүнд:

- 5.1. Цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл
- 5.2. Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд
- 5.3. Зүлэгжүүлэлтийн ажилд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүд
- 5.4. Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл
- 5.5. Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд
- 5.6. Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд
- 5.7. Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд
- 5.8. Мод, сөөгийн хэлбэржүүлэлтэд ашиглах багаж, тоног төхөөрөмж
- 5.9. Хот тохижилтын цэвэрлэгээ, арчилгаанд ашигладаг багаж
- 5.10. Мод, сөөгийн шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж тоног төхөөрөмжүүд
- 5.11. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм

5.12. Ногоон байгууламжийн өвчин, хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл

5.1 ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ

Цэцэрлэгчийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, тэдгээрийн ашиглалтын хугацааг байгууллага нь хөдөлмөрийн хуулийн дагуу дотоод журамдаа тусгасан байна.

5.1 Цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Хамгаалалтын малгай 	Хамгаалалтын малгай нь толгой дээр аливаа гаднын биет унах, эсвэл шидэгдэж ирэхээс хамгаалах зориулалттай юм.	➤ Хэрэглэхээс өмнө бүрэн бүтэн байдлыг шалгана. ➤ Зориулалтын дагуу хэрэглэнэ. ➤ Ургамал хамгаалах химийн бодистой харьцаж ажиллах үед резин юм уу хуванцар эдээр хийсэн малгай өмсөх шаардлагатай.
Нүүрний хамгаалалт 	Цахилгаан хөрөөгөөр мод хөрөөдөх, хэлбэржүүлэх, зүлэг хадах явцад ургамлын хаягдал, чулуу үсрэх аюулаас нүүрийг хамгаална.	➤ Хэрэглэхээс өмнө бүрэн бүтэн байдлыг шалгана. ➤ Зориулалтын дагуу хэрэглэнэ. ➤ Гүйцэтгэх ажлын нөхцөлд тохирсон байна.
Нүдний шил 	Нүдийг гадна нөхцөлөөс үүсэж болзошгүй ослоос хамгаална.	
Хамгаалалтын бээлий 	Ажлын нөхцөлөөс үүсэж болзошгүй гэмтэл, өвчлөлт, харшил зэргээс хамгаалж, ажилд тохируулж өмсөнө. Чанарын баталгаажуулалт, KWF-ийн дүрс хяналтын дүрс тавьж өгсөн бээлийг ашиглана.	➤ Бээлий нь хийж буй үйл ажиллагаа бүрд тохирсон байх ёстой. ➤ Хэрэглэхээс өмнө бүрэн бүтэн байдлыг шалгана. ➤ Бээлийг зориулалтаар нь ашиглахад гарын арьсанд сөрөг нөлөөлөл, цочрол үзүүлэхгүй байх ёстой.

Ажлын хувцас 	Орчин үеийн даавуун материалаар хийгдсэн байх. Тухайлбал сунадаг, агааржуулалт сайтай байх. Хажуу талын хармаануудыг болж өгвөл цахилгаантай хийж өгөх. Багаж хэрэгсэл хийх халаастай байна. Өвдөг хамгаалах бэхлэлтэй. Хөлийн дээд хэсэг чийгийн хамгаалалттай. Арчлахад хялбар хурдан хатдаг байх шаардлагатай.	➤ Хүний биед сөрөг нөлөө үзүүлэхгүй материалаар хийгдсэн байна. ➤ Цахилгаанжихгүй. ➤ Хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалж ажлын тусгай хувцасны ашиглалт эдэлгээний хугацаа өөр байна. ➤ Хувийн хамгаалалтын хувцас хэрэгслийг тогтмол хугацаанд шалгаж, шаардлагатай бол шинэчилж, солих арга хэмжээ авна.
Ажлын өвлийн хувцас 	Хүний биеийг хүйтний улиралд хайрахаас сэргийлж, үстэй болон ноосон дотортой байна. Дотор нь салгах зориулалтаар хийгдсэн. Дотрын материал нь хувцсыг өмсөх тайлахад хялбар байна. Дотор нь өмсөж буй хувцастай үрэлт үүсгэхгүй байна.	➤ Цэцэрлэгчин нь улиралд тохирсон дулаан, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангагдана. ➤ Осгох, хөлдөлтийн үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байна.
Хамгаалалтын гутал 	Ажлын нөхцөлөөс шалтгаалж хөлийг зүсэх, хатгах, харшлах, осгох, хөлдөх, норх, бяцрах, цахилгаанжих, халтирах зэрэг аюулаас хамгаална. Улирлын ажилд тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөнө.	➤ Ажлын нөхцөлөөс хамаарч зориулалтын материалаар хийгдсэн, ашиглалтын тэмдэглэгээтэй байна. ➤ HR-халалтаас хамгаалсан- Гутлын ул өндөр температурт тэсвэртэй материалаар хийсэн. ➤ INS-хүйтнээс хамгаалсан- Хүйтэн орчинд ажиллахад зориулагдсан байна.
Хамгаалалтын усны гутал 	Хамгаалалтын зориулалт бүхий усны гутал дээр ус нэвтрүүлэхгүй байх хатуу шаардлага тавьдаг.	➤ Урт хугацаагаар хэрэглэхээс зайлсхийх. ➤ Усны гутал нь синтетик, хиймэл үстэй материалаар хийсэн оймстой, хөлд эвтэйхэн байх шаардлагатай.

Гутлын нэмэлт улавч 	Гутлын гадна талаар углаж хэрэглэнэ. Халтиргаа, гулгаанаас хамгаална. Налуу газарт ажиллах үед хэрэглэнэ.	➤ Зориулалтын дагуу зөвхөн шаардлагатай нөхцөлд хэрэглэнэ. ➤ Гутлын хэмжээнд тохируулж хэрэглэнэ.
Ус нэвтрүүлдэггүй хувцас 	Ус, чийг нэвтрүүлэхээс хамгаалах хувцсыг борооны улиралд, ургамлын өвчин хортонтой тэмцэх, мод шохойдох, будах ажлын үед хэрэглэнэ.	➤ Урт хугацаагаар хэрэглэхээс зайлсхийх ➤ Ус чийгээс хамгаалах хувцсыг тайлсны дараа биеийн салхи цохихоос хамгаалж, биеийг хуурай алчуураар арчих, дулаан хувцас өмсөх хэрэгтэй. ➤ Химийн бодист тэсвэртэй байх.
Химийн бодисонд тэсвэртэй бээлий 	Ургамал хамгааллын бодис, найруулах цацах болон бордоо ашиглахад хэрэглэнэ. Химийн бодисыг хэрэглэхдээ биед нэвчихээс хамгаалж, зориулалтын хувцсыг зөв, бүрэн өмссөн байна.	➤ Бээлийг үлээж бугуйн хэсгийг атгаж, шахаж бүтэн байдлыг шалгана. ➤ Бээлий шингэн нэвтрэхгүй материалаар хийгдсэн байна. ➤ Шаардлагатай тохиолдолд хөвөн, даавуун, арьсан бээлийн гадуур давхарлаж өмсөнө.
Хошуувч 	Ургамал хамгаалан өвчин хортон, хог ургамалтай тэмцэн хор цацах, тоос шороотой орчинд ажиллах үе шүүлтүүртэй амны хамгаалалт хэрэглэнэ.	➤ Хошуувч шүүлтүүртэй байна. ➤ Шүүлтүүрийг ашиглалтын хугацаа дууссан үед солино.
Хөдөлмөр хамгааллын хантааз	Ажилтныг аюулаас хамгаалах гэрлийн ойлттой хувцас. Онцгой нөхцөлд хэрэглэгдэх хантааз.	➤ Аюулгүй ажиллагааг хангахад зориулагдсан цацруулагчтай байна. ➤ Замын хөдөлгөөнд ойр, өндөрт, үзэгдэх орчин бага, нөхцөлүүдэд ажиллах үед өмсөнө.

		
Шилбэний хамгаалалт 	Шилбэний хамгаалалт нь зүлэгжүүлэх болон бусад тохижилтын ажилд ажиллах үед хэрэглэнэ.	➤ Хөлийн доод хэсгийг хог хаягдал, чулуунаас хамгаалдаг.
Гарын хамгаалалт 	Гарын хамгаалалт нь мод бутыг танаж тайрах, хэлбэржүүлэхэд гарыг өргөс, хатсан мөчир, үзүүртэй ирмэг зэргээс хамгаалах зориулалттай.	➤ Бут сөөг танах, тайрах үед гарын шууг гэмтэхээс хамгаална.
Хөлийн хамгаалалт 	Энэ нь хөрөөнөөс хамгаалах хэрэгсэл биш бөгөөд тоос шороо нэвтрэх, гэмтлээс хамгаалах зориулалттай хөлийн хамгаалалт.	➤ Бут сөөг танах, тайрах үед хөлийг гэмтэхээс хамгаална.

5.2 ХӨРС БОЛОВСРУУЛАЛТАД АШИГЛАГДАХ ҮНДСЭН ТЕХНИК, БАГАЖ, ХЭРЭГСЛҮҮД

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажилд талбайг бэлтгэх, хөрс, хуулах, хөрсжүүлэх, хагалах, сийрүүлэх, тэгшлэх зэрэг ажлуудад ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын заавар. Хөрс боловсруулах үндсэн зорилго нь ургамал ургах тохиромжтой нөхцөлийг бүрдүүлж өгнө.

Хүснэгт 6.2 Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Жижиг трактор	Мод тарих, хөрс боловсруулах, арчилгааны ажлуудын үед хөдөлгүүрүүдийг холбож цэцэрлэгийн хөдөлмөр хэмнэнэ.	➤ Үндсэн трактортой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан байна. ➤ Тракторт холбох хөдөлгүүр

	Үйлдвэрээс зөвлөмжийн өгсөн ашиглалт, дагуу зориулалтаар хэрэглэнэ.	тус бүр дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө. ➤ Хөдөлгүүр тус бүрийн тохиргоо, ажлын дарааллыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дагаж мөрдөнө.
Явган трактор 	Бага орон зайд, том оврын техник ажиллах боломжгүй, техник тоног төхөөрөмжийн хязгаарлалттай орчинд явган тракторыг ашиглана.	➤ Жижиг трактор жолоодогч нь жолоодох эрх бүхий ангилалтай үнэмлэхтэй байна. ➤ Тракторын жолооч нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж доргилтын хамгаалалттай бүс, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэглэлтэй байна.
Анжис 	Жижиг трактор болон явган тракторт угсарч хөрсийг хагална. Анжсаар атар газрыг хагалж хөрс боловсруулахад ашиглана.	➤ Жижиг трактор болон явган тракторт угсарч хэрэглэх үед жолоодогч нь мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байх ба хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтална. ➤ Хөрс боловсруулах анжсыг тракторт бат бэх холбосон байх хэрэгтэй.
Сийрүүлэгч 	Бүх төрлийн хөрсийг буталж боловсруулна. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт хийх талбайн хэмжээнээс хамаарч хөрсийг боловсруулахад ашиглана.	➤ Цэцэрлэгчийн ажилд ашиглагдах моторт хөдөлгүүр, тоног, төхөөрөмжтэй ажиллах ажилтан нь мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байх ба хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтална.
Сийрүүлэгч 	Үйлдвэрээс зөвлөмжийн өгсөн ашиглалт, дагуу зориулалтаар хэрэглэнэ.	➤ Машин механизм, тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх, гарахын өмнө бүрэн бүтэн байдлыг шалгах. ➤ Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл өмсөнө.
Сийрүүлэгч		

		
Борной 	Хөрний гадаргууг жигд бутлаж, тэгшлэх, зориулалттай.	➤ Жижиг трактор болон явган тракторт угсарч хэрэглэх үед жолоодогч нь мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байх ба хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтална. ➤ Хөрс боловсруулах борнойг тракторт бат бэх холбосон байх хэрэгтэй.



Зураг 6.1 Талбайн хөрс боловсруулалт

5.3 ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД

Зүлэгжүүлэлтийн ажилд зүлэг үрлэх, үр бордоо цацах, хөрсний гадаргууг нягтруулах зэрэг ажлуудад ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг орууллаа.

MNS 6260: 2020 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах стандартын дагуу Энэхүү стандарт нь хот, суурин газрын нийтийн эзэмшил, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжийн талбайг зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлахад хамаарна.

Хүснэгт 6.3 Зүлэгжүүлэлтийн ажилд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Зүлгийн үрлэгч 	Их хэмжээний талбайг үрлэх боломжтой. Зүлгийн үр тарих зориулалтаар ашиглана.	➤ Үрлэгчийг ажилд бэлэн эсэхийг ажилд гарахын өмнө шалгана. ➤ Үрлэгчийг үр бордоогоор цэнэглэхдээ гүйцэд зогссон нөхцөлд механикжсан буюу гар аргаар гүйцэтгэнэ. ➤ Ажил гүйцэтгэгчид нь гүйцэтгэж байгаа ажлын талаар аюулгүй ажиллагааны зааварчилгааг заавал авсан байна.
Зүлгийн үрлэгч 	Зүлгийн үр тарих, зүлгийг тайрах, тэгшлэх зэрэг зориулалтаар ашигладаг олон талт машин. Зөөврийн болон хадгалах зориулалттай.	➤ Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл өмсөнө.
Үр, бордоо цацагч 	Бага хэмжээний талбайн зүлэгжүүлэлтэд үрийг үрлэх, бордоо цацах зориулалтаар ашиглана.	➤ Үрлэгчийг ажилд бэлэн эсэхийг ажилд гарахын өмнө шалгана. ➤ Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл өмсөнө.
Гар үр, бордоо цацагч 	Зүлэгний үрийг үрлэх, бордоо цацах зориулалтаар ашигладаг.	

Гадаргуу тэгшлэгч 	Хөрсний гадаргууг тэгшлэх, нягтруулах, зүлэгний үрийг хөрсөнд шигтгэж өгөх зориулалттай.	➤ Ажил гүйцэтгэгч нь гүйцэтгэж байгаа ажлын талаар аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан байна. ➤ Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл өмсөнө.
Тармуур 	Хөрсийг самнаж тэгшлэх, няцалж, бутлах, ургамлын мөр хоорондын хөрсийг сийрүүлэх, талбайн өвс, ургамал, чулуу зэргийг самнаж, түүж, цэвэрлэх зэрэг олон төрлийн ажлыг гүйцэтгэх зорилгоор ашиглана.	➤ Гар багажтай холбоотой аюул, эрсдэл ихэвчлэн зүй бус хэрэглээ, зохисгүй ашиглалт, зориулалтын бус зүйлээр орлуулан хийснээр осол гэмтэлд өртөх эрсдэлтэй. ➤ Гар багажийн аюулгүй ажиллагаа нь ажил үүргийн төрөлд тохирсон багажийг сонгох.
Малтуур 	Сулласан шороог нааш цааш нь малтаж, засаж тэгшлэх, хог ургамал чулуу зэргийн малтаж цэвэрлэх зориулалтаар ашиглана. Хөрсийг бутлах, тэгшлэх, хайрцаг хийх, шан татах, сэндийлэх гар цавчуур юм. Шигүү таригдсан ургамлын мөр хоорондын хөрсийг сийрүүлэх зорилгоор мөн ашиглана.	➤ Багажийн бариул их биедээ найдвартай бэхлэгдсэн эсэх, ирмэг, өнцгийн бүрэн бүтэн байдлыг сайтар нягтлан шалгах хэрэгтэй. ➤ Гар багажийг хэрэглэж байхдаа шидэхгүй байх, хөл гар биеийн хэсгийг гэмтээхээс болгоомжлох, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна.
Хүрз гурвалжин 	Цэцэрлэгийн хөрсийг хагалж тэгшлэн, няцалж бутлах, засах олон төрлийн ажлуудыг гүйцэтгэх зорилгоор ашигладаг. Хүнд шавранцар хөрсийг хурц үзүүртэй шөвгөр хүрзээр хагалж боловсруулна.	
Хүрз дөрвөлжин 	Хөрсийг ачиж тээвэрлэх, буулгах, сул хөрсөнд ашиглах зориулалттай. Хөнгөн хөрсийг дөрвөлжин хүрзээр хагалж боловсруулах нь тохиромжтой байдаг.	

Жоотуу 	Хөрс шороог ухах, хагалахад зориулагдсан гар хэрэгсэл юм. Хатуу хөрс, чулуурхаг газрыг хагалах, нүх ухахад ашиглаж болно.	
Сэрээ 	2-3, 4-5 ширхэг шүдтэй сэрээгээр хагалсан шороог сийрүүлэх болон бусад цэцэрлэгжүүлэлтийн ажилд хэрэглэнэ.	
Тэрэг 	Цэцэрлэгжүүлэлт ажилд зөөвөрлөх зориулалттай. Өтөг бууц шороо, хог ургамал, талбайн чулуу, хогийг зөөхөд ашиглагдана.	➤ Зөөж тээвэрлэхэд бэлэн эсэхийг ажилд гарахын өмнө шалгана. ➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна.

5.4 ЗҮЛЭГТ ТАЛБАЙГ АРЧЛАН ХАМГААЛАХАД ШААРДЛАГАТАЙ БАГАЖ, ХЭРЭГСЭЛ

Зүлэгт талбайн хог ургамлыг цэвэрлэх, хадах, тэгшлэх, хэлбэржүүлэх зэрэг ажлуудад ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг орууллаа.

Хүснэгт 6.4 Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Зэрлэг цавчигч 	Ил талбайн зэрлэгийг цавчиж, хусаж авах зориулалттай. Мөн хөрсийг сийрүүлэх, суллахад хэрэглэж болно.	➤ Гар багажийг хэрэглэж байхдаа шидэхгүй байх, бусдад багаж дамжуулахдаа гараас гарт дамжуулах буюу газар тавьж дамжуулна. ➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна

Үүрдэг хадуур 	Зүлгийг хадах зориулалтаар ашиглана. Хэрэглэхэд хялбар хөнгөн авсаархан.	➤ Зүлэг хадаж, тайрах үед зүлгийн гар хадуурын бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг сайтар хангаж шалгаж ажиллана. ➤ Насанд хүрээгүй хүнийг хадуур ажиллуулахыг хориглоно. ➤ Ажилчин цэцэрлэгийн багаж хэрэгслийг аюулгүй ашиглах талаар чиглэсэн зааварчилгаа авах ба мэргэжилтний өгсөн зааврын дагуу хэрэглэнэ.
Зүлэг тэгшлэгч машин 	Зүлэг тэгшлэх, хадах зориулалтаар ашигладаг. Үйлдвэрлэгчээс өгсөн ашиглалтын дагуу хэрэглэх нь ашиглалтыг уртасгана.	➤ Талбайн хэмжээ, зориулалтаас хамаарч багажийг сонгох. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна
Зүлэг тэгшлэгч машин 	Тэгш гадаргуутай талбайн зүлэг тэгшлэх, хадах зориулалтаар ашиглана. Үйлдвэрлэгчээс өгсөн ашиглалтын дагуу хэрэглэх нь ашиглалтыг уртасгана.	
Зүлэг тэгшлэгч машин 	Их хэмжээний талбайд зүлэг тэгшлэх, хадах зориулалтаар ашиглана. Талбайд урт хугацаагаар ажиллах боломжтой. Үйлдвэрлэгчээс өгсөн ашиглалтын дагуу хэрэглэх нь ашиглалтыг уртасгана.	➤ Цэцэрлэгчийн ажилд ашиглагдах моторт хөдөлгүүр, тоног, төхөөрөмжтэй ажиллах ажилтан нь мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байх ба хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтална. ➤ Машин механизм, тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх, гарахын өмнө бүрэн бүтэн байдлыг шалгах. ➤ Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл өмсөнө.
Гар хадуур	Өндөр ургасан зэрлэгийг хадаж авах зориулалтаар ашиглана.	➤ Насанд хүрээгүй хүнийг хадуур ажиллуулахыг хориглоно. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна.

		
Зүлгийн хайч 	Зүлэгжүүлсэн ирмэгүүдийг зориулалттай. талбайн захилах	➤ Насанд хүрээгүй хүнийг хайчаар ажиллахыг хориглоно. ➤ Ажилчин цэцэрлэгийн багаж хэрэгслийг аюулгүй ашиглах талаар чиглэсэн зааварчилгаа авах. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байх.
Зүлгийн хайч 		
Зүлэг хэлбэржүүлэгч гар хайч 	Хашаа, цэцгийн мандал, модлог ургамлын хослол зохиомжийн ойролцоо ургасан зүлгийг тэгшлэхэд ашиглана.	➤ Насанд хүрээгүй хүнийг зүлэг хэлбэржүүлэгчийг ажиллуулахыг хориглоно. ➤ Ажилчин цэцэрлэгийн багаж хэрэгслийг аюулгүй ашиглах талаар чиглэсэн зааварчилгаа авах ёстой. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна
Савар 	Зүлэгжүүлэлт, цэцэрлэгийн цэвэрлэгээнд ашиглана.	➤ Бусдад багаж дамжуулахдаа гараас гарт дамжуулах буюу газар тавьж дамжуулна. ➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна.

РН хэмжигч 	Ус болон хөрсний хүчил шүлтийн орчин (РН), температурыг хэмжинэ.	➤ Үйлдвэрлэгчээс өгсөн ажиллуулах болон хэрэглэх зөвлөмжийн дагуу ашиглана. ➤ Хэрэглэхийн өмнө бүрэн бүтэн байдлыг шалгах.
Термометр 	Гадна болон дотор агаарын харьцангуй чийгшил хэмжих зориулалттай.	



Зураг 6.2 Үрийг гараар нэгэн жигд цацах



Зураг 6.3 Үрийг механизмаар цацах



Зураг 6.4 Зүлгийн тайралт, арчилгаа



5.5 ЦЭЦЭГТ БАЙГУУЛАМЖИЙН АРЧИЛГААНД АШИГЛАГДАХ БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД

Цэцэгт байгууламжийн арчилгаанд хөрсийг тармах, тэгшлэх, хөрсийг бутлах, үрслэг шилжүүлэн суулгах зэрэг ажлуудад ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг орууллаа.

MNS 6259: 2011 Ганц наст цэцэг тарих арга стандартын дагуу тарина. Цэцгийг үр болон үрслэгээр тарина.

Хүснэгт 6.5 Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Гар тармуур 	Хөрсийг тармах, тэгшлэх, ургамлын үндсийг бутлах зэрэг олон зориулалтаар ашиглана. Бага орон зайд ашигладаг.	➤ Гар багажийг хэрэглэж байхдаа шидэж дамжуулахгүй байх. ➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна. ➤ Багажийг ажилд хэрэглэж дуусмагц шороо тоосыг цэвэрлэж, эрэг боолтыг нь тосолж байх.
Шүдэт гар гапуу 	Хөрсийг бутлах, тэгшлэх, хайрцаг хийх, шан татах, сэндийлэх зэрэг зориулалтаар ашиглана.	➤ Багажийг ус чийг орохгүй, хуурай газар хадгална.
Үрслэг суулгагч 	Бойжуулсан үрслэгийг ил цэцгийн талбайд суулгах зориулалтай.	➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна.
Гар ухуур 	Жижиг гар ухуураар хөрс онгилж, ургамлын суулгац, цэцэг ногооны үрслэг шилжүүлэн суулгах, үндэслэг ургамлыг ухаж авах зэрэгт хэрэглэнэ.	

3 шүдэт сийрүүлэгч 	Мөр хооронд тармах, сийрүүлэх, хөрсийг бутлах зориулалттай. Шүдэт мөр гаргагчийг 15, 25, 35, 45, 60 см-ын зайтай өргөн мөрөөр үр суулгахад хэрэглэнэ.	
Гар гаануу 	Хөрсийг бутлах, тэгшлэх, хайрцаг хийх, шан татах, сэндийлэх зориулалттай.	➤ Гар багажийг хэрэглэж байхдаа шидэхгүй байх, бусдад багаж дамжуулахдаа гараас гарт дамжуулах буюу газар тавьж дамжуулна. ➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна
Хоовонт хавтан 	Бүх төрлийн цэцгийн үрсэлгээ ургуулах зорилгоор ашигладаг полиэтилен хоовон.	Ашиглалтын өмнө бүтэн байдлыг шалгана.
Бортого 	Бүх төрлийн цэцгийн үрслэг бойжуулж, тарих зориулалтаар ашигладаг.	

5.6 МОД, СӨӨГИЙН ТАРИЛТАД АШИГЛАГДАХ БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД

Мод, сөөг тарих нүхийг бэлтгэхэд ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг орууллаа.

Мод сөөгийн суулгацын нүхийг бэлтгэх, суулгахад доорх стандартуудыг мөрдөнө. Үүнд:

- MNS 6258-1: 2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах.
- MNS 6139: 2010 Шилмүүст модны суулгац. Техникийн шаардлага.
- MNS 6141: 2010 Навчит модны суулгац. Техникийн шаардлага.
- MNS6255: 2011 Сөөгийн суулгац. Ерөнхий шаардлага

6.6 Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Хүрз 	Мод, сөөгийн суулгацыг тарихад ашиглана.	➤ Гар багажийг хэрэглэж байхдаа шидэхгүй байх, бусдад багаж дамжуулахдаа гараас гарт дамжуулах буюу газар тавьж дамжуулна. ➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна
Ачааны машин 	Модны суулгацыг зөөх, тээвэрлэх зориулалттай. Үржил шимт хөрс, элс, бууц, усалгаа, талбайн цэвэрлэгээнд ашиглана.	➤ Хөдөлгүүр тус бүрийн тохиргоо, ажлын дарааллыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дагаж мөрдөнө. ➤ Ачааны машин жолоодогч нь жолоодох эрх бүхий ангилалтай үнэмлэхтэй байна. ➤ Ачааны машины жолооч нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэглэлтэй байна.
Экске 	Их хэмжээний талбайн мод, сөөгийн суулгацын нүх, шуудуу ухах зориулалттай.	➤ Тээвэрлэлт хийх техникийг бүрэн зогссон үед тээвэрлэгч жолоочийг зөвшөөрөл өгсөн тохиолдолд ачиж буулгах ажлыг эхэлнэ.
Нүх ухагч	Мод сөөгийн суулгацын нүх бэлтгэх зориулалттай. Суулгацын төрөл,	➤ Механикжсан ажил гүйцэтгэгчид нь гүйцэтгэж байгаа ажлын талаар аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан

	хэмжээнээс хамааран нүх ухагчийг сонгоно.	байна. ➤ Тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх, гарахын өмнө бүрэн бүтэн байдлыг шалгах ➤ Нүх, суваг шуудууг ухахдаа багажийг зөв барьж хөл гар, биеийн хэсгийг гэмтээхээс болгоомжилж ажиллана. ➤ Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл өмсөнө.
Нүх ухагч 	Мод, сөөг тарих нүхийг бэлтгэх зориулалттай.	➤ Хөдөлгүүр тус бүрийн тохиргоо, ажлын дарааллыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дагаж мөрдөнө. ➤ Трактор жолоодогч нь жолоодох эрх бүхий ангилалтай үнэмлэхтэй байна.
Нүх ухагч 	Том хэмжээний талбайд мод, сөөг тарих нүхийг бэлтгэх зориулалттай.	➤ Жолооч нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэглэлтэй байна. ➤ Техникийг бүрэн зогсож талбайг чөлөөлж зөвшөөрөл өгсөн тохиолдолд мод, сөөг тарих ажлыг эхэлнэ.

5.7 МОД, СӨӨГИЙН АРЧИЛГААНД АШИГЛАГДАХ БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД

Мод, сөөгийн титмийн хэсгийг сийрүүлэх, өвчин хортонд өртсөн мөчрийг огтлох, цэвэрлэхэд ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг орууллаа.

Хүснэгт 6.7 Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Мөчрийн хайч 	Мод, сөөгийн мөчрийг огтлох зориулалттай. Мөчрийг залгах, мөчир бэлтгэх, суулгацын үндсийг тайрах, залуу	➤ Насанд хүрээгүй хүнийг хайчаар ажиллахыг хориглоно. ➤ Ажилчин цэцэрлэгийн багаж хэрэгслийг аюулгүй ашиглах талаар чиглэсэн

	модны хэлбэржүүлэх, мод, сөөгийн тайралтыг ашиглана. титмийг жимслэх таналт хийхэд	зааварчилгаа авах ёстой. ➤ Хэрэглэж дууссаны дараа зориулалтын гэрт хийж хадгалах, гутлын түрий, хувцасны халаасанд хийхийг хориглоно.
	Мөчрийг хайч нь олон төрөлтэй бөгөөд ажлын зориулалтаас хамааран сонгоно.	➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна. ➤ Бариул нь гулсдаггүй атгах чадвар сайн байх.
		
		
		
Мөчир залгалтын хутга 	Мөчир нахиа залгах зориулалттай. Эгц шулуун иртэй, хутганы ирний эсрэг талын үзүүрт мөчир нахиаг залгахаар зүссэн холтсыг хөндийрүүлж өгөх үүрэг зориулалтаар ашигладаг.	➤ Цэцэрлэгчин ургамлын өргөс, хатсан мөчир, үзүүртэй ирмэг зэргээс хамгаалсан бээлий өмсөнө. ➤ Ирмэг, хурц иртэй багажийг хэзээ ч бие рүүгээ буюу дотогш чиглэлтэй хэрэглэж болохгүй. ➤ Халаасандаа зөөвөрлөж болохгүй. ➤ Хоорондоо авч өгч, шилжүүлэх тохиолдолд гараас гарт гүйцэт бариулна. ➤ Багаж тус бүртэй ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгааг авсан байх шаардлагатай.
Мөчир залгалтын хутга 	Нахиа залгахын өмнө шилбийг цэвэрлэх, бүдүүрч томорсон найлзуур, шинэ залуу өргөслөг мөчир, өрсөлдөгч мөчир болон бусад мөчир салааг тасалж танах, ишинд хэрчлээс ховил гаргахын өмнө орчин тойрных нь шарх сорви гэх мэтийг арилгаж цэвэрлэх, шархыг эмчлэх зэрэгт өргөн хэрэглэдэг.	

Цэцэрлэгийн хөрөө 	Энэ хөрөөг дотор нь татуургатай, татуургагүй гэж ангилна. Эвхдэг хөрөөгөөр хөрөөдөх боломжгүй мөчрийг сийрүүлэх, хэт хурц өнцгөөр байрласан мөчир гишүү зэргийг огтолж тайрахад ашиглана. Цэцэрлэгийн хөрөөнүүдийн шүд нь эгц, налуу гэсэн байрлалтай байна.	➤ Багаж тус бүртэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан байх шаардлагатай. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна. ➤ Халаасандаа зөөвөрлөж болохгүй. ➤ Хоорондоо авч өгч, шилжүүлэх тохиолдолд гараас гарт гүйцэт бариулна
		
Мөчир огтлогч 	Мод, сөөгийн титмийн дээд хэсгийн мөчрийг огтлох зориулалттай. Мод, сөөгийн титмийн дээд талын гар хүрэхгүй мөчир гишүү тусгай шат хэрэглэхгүйгээр огтолж танахад ашиглана.	➤ Насанд хүрээгүй хүнийг хайчаар ажиллахыг хориглоно. ➤ Ажилчин цэцэрлэгийн багаж хэрэгслийг аюулгүй ашиглах талаар чиглэсэн зааварчилгаа авах ёстой. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна. ➤ Цэцэрлэгчин нь хайчийг байнга дээш өргөж удаан ажиллуулдаг тул хөнгөн нарийн иштэй байх нь зохимжтой.
Мөчир огтлогч 		
Мөчир огтлогч 		

Мөчир огтлох цахилгаан хөрөө 	Мод бут, мөчир тайрах, тэгшлэх зориулалтаар ашигладаг.	➤ Насанд хүрээгүй хүнийг хөрөөгөөр ажиглуулахыг хориглоно. ➤ Багаж тус бүртэй ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгааг авсан байх шаардлагатай. ➤ Хөрөөний гар бариул нь ажлын байрлалд тохирсон эсэхийг ажилд гарахын өмнө шалгах. ➤ Хөрөөний хоёр гарт ачаалал тэнцүү эсэх. ➤ Хөрөөдөж байх үед хөдөлгүүрийн хэсэгт хүрэх, оролдохыг хориглоно. ➤ Хөрөө дуу чимээ ихтэй багажтай харьцахдаа сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглэнэ. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна.
Шат 	Мод, сөөгийн мөчир тайрахад зориулагдсан. Эвхэгддэг А хэлбэртэй, шулуун суудаг шат зэрэг олон төрөл байдаг.	➤ Ажилчин цэцэрлэгийн багаж хэрэгслийг аюулгүй ашиглах талаар чиглэсэн зааварчилгаа авах. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна. ➤ Ашиглахаас өмнө эвдрэл гэмтлийг шалгах.
Хайч хутга ирлэгч хуурай 	Мод, сөөгийн мөчир тайрах, хэлбэржүүлэгч, огтлогч, цэцгийн хайч зэргийг ирлэх зориулалтаар ашиглана.	➤ Бариул эх биетэйгээ сайтар бэхлэгдсэн байна. ➤ Ирлэх үед хамгаалах хэрэгсэл өмссөн байна.
Гар точил 		

Хутга ирлэгч зөөлөн билүү 	Цэцэрлэгжүүлэлтийн багажийг ирлэх зориулалтаар ашиглана. Точилд үрж бүдүүн ир гаргасны дараа зөөлөн билүүнд үрснээр нарийн иртэй болно.	
--	---	--

5.8 ХОТ ТОХИЖИЛТЫН ЦЭВЭРЛЭГЭЭ, АРЧИЛГААНД АШИГЛАГДАХ БАГАЖ

Хот тохижилтын цэвэрлэгээ, арчилгаанд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмуудын зориулалт, ашиглалт, хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааны ерөнхий заавар орууллаа.

Хүснэгт 6.8 Хот тохижилтын цэвэрлэгээ үйлчилгээнд ашиглагдах багаж

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Мод цавчигч 	Мод, сөөгийн хэлбэржүүлэлтээс гарсан мөчрийг жижиглэн зомгол болгон цэвэрлэх зориулалттай.	Хөдөлгүүр тус бүрийн тохиргоо, ажлын дарааллыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дагаж мөрдөнө. Цэцэрлэгчин нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэглэлтэй байна.
Шүүр 	Явган зам талбайн цэвэрлэгээнд ашиглана. Тохижилтын талбайн хэмжээнээс хамааран шүүрийн төрлийг сонгон хэрэглэнэ.	➤ Гар багажийн аюулгүй ажиллагаа нь ажил үүргийн төрөлд тохирсон багажийг сонгох. ➤ Багажийн бариул их биедээ найдвартай бэхлэгдсэн эсэх, ирмэг, өнцгийн бүрэн бүтэн байдлыг сайтар нягтлан шалгах хэрэгтэй.
Механик шүүр 		Гар багажийг хэрэглэж байхдаа шидэхгүй байх, хөл гар биеийн хэсгийг гэмтээхээс болгоомжлох, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна

Цас цэвэрлэгч 	Явган зам талбайн цасыг цэвэрлэх зориулалттай.	➤ Хөдөлгүүр тус бүрийн тохиргоо, ажлын дарааллыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дагаж мөрдөнө. ➤ Цас цэвэрлэгчийг жолоодогч нь жолоодох эрх бүхий ангилалтай үнэмлэхтэй байна. ➤ Цас цэвэрлэгчийн жолооч нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэглэлтэй байна.
Цас цэвэрлэгч машин 	Зам талбайн цасыг цэвэрлэх зориулалттай.	
Хогын сав 	Гудамж, зам талбайн цэвэрлэгээнд ашиглагдана.	➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна.
Навч цэвэрлэгч 	Ногоон байгууламжийн хавар, намрын улиралд ашиглагдах цэвэрлэгээний зориулалттай. Навч цэвэрлэхэд ашиглана.	➤ Үйлдвэрлэгчээс өгсөн ажиллуулах болон хэрэглэх зөвлөмжийн дагуу ашиглана. ➤ Хэрэглэхийн өмнө бүрэн бүтэн байдлыг шалгах. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна.



Зураг 6.5 Цэцэрлэгжүүлсэн талбайн навчийг цэвэрлэх

5.9 МОД, СӨӨГИЙН ХЭЛБЭРЖҮҮЛЭЛТЭНД АШИГЛАГДАХ БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мод, сөөгт хэлбэржүүлэлтэд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалт, хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааны ерөнхий зааврын орууллаа.

Мод, сөөгийг хэлбэржүүлэхдээ MNS 6772:2019 Мод сөөгийг хэлбэржүүлэх техникийн шаардлагыг дагаж мөрдөнө.

6.9 Мод, бут сөөгийн хэлбэржүүлэлтэд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Хэлбэржүүлэгч хөрөө 	Мод, сөөгийн титмийн оройн хэлбэржүүлэх зориулалттай. хэсгийг Мод сөөгийн хэлбэржүүлэлтийн	➤ Насанд хүрээгүй хүнийг хөрөөгөөр ажилдуулахыг хориглоно. ➤ Багаж тус бүртэй ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгааг авсан байх шаардлагатай. ➤ Ажиллах бэлэн байдлыг шалгах. ➤ Хөрөөний гар бариул нь ажлын байрлалд

Хэлбэржүүлэгч хөрөө 	зориулалтаас хамаарч, сольж хэрэглэх боломжтой багаж.	тохирсон эсэх. ➤ Хөрөөний ирний чиглүүлэгч нь хагарч гэмтээгүй, шүд нь бүрэн сууж, түргэн эргэлтэд саадгүй байх боломжоор хангах. ➤ Хөрөөдөж байх үед хөдөлгүүрийн хэсэгт хүрэх, оролдохыг хориглоно. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна. ➤ Хэлбэржүүлэлтийн ажлыг гүйцэтгэгч нь цэцэрлэгчийн сертификаттай байх.
Хэлбэржүүлэгч хөрөө 	Ногоон хана, таримал хашлага, эмжээр хэлбэржүүлэх зориулалттай. Үйлдвэрлэгчийн зааврыг дагуу ашиглана	
Хэлбэржүүлэгч хөрөө 		
Мөчир огтлогч 	Мод, сөөгийг хэлбэржүүлэн засах зориулалттай. Цэвэрлэгээний, сийрүүлэх, залуужуулах огтлолд ашиглагдана.	➤ Насанд хүрээгүй хүнийг хайчаар ажиллахыг хориглоно. ➤ Ажилчин цэцэрлэгийн багаж хэрэгслийг аюулгүй ашиглах талаар чиглэсэн зааварчилгаа авах ёстой.
Хэлбэржүүлэх хайч 	Ногоон хана, таримал хашлага, эмжээр хэлбэржүүлэх зориулалттай.	➤ Хэрэглэж дууссаны дараа зориулалтын гэрт хийж хадгалах, гутлын түрий, хувцасны халаасанд хийхийг хориглоно. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна. ➤ Бариул нь гулсдаггүй

Хэлбэржүүлэгч хайч 	Цэвэрлэгээний, сийрүүлэх, залуужуулах, хэлбэржүүлэх огтлолд ашиглагдана.	атгах чадвар сайн байх.
Кран 	Мод, сөөгийн хэлбэржүүлэлтэд ашиглагдах бүхээгтэй кран.	➤ Насанд хүрээгүй хүнийг хөрөөгөөр ажилдуулахыг хориглоно. ➤ Багаж тус бүртэй ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгааг авсан байх шаардлагатай. ➤ Ажиллах бэлэн байдлыг шалгах. ➤ Хөрөөний гар бариул нь ажлын байрлалд тохирсон эсэх. ➤ Хөрөөдөж байх үед хөдөлгүүрийн хэсэгт хүрэх, оролдохыг хориглоно. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна.
Хэлбэржүүлэгч хөрөө 	Нэгэн жигд хэлбэржүүлэх, өндрийн тохируулагчтай таримал хашлага, хана хэлбэржүүлэхэд ашиглагдана.	➤ Хэлбэржүүлэлтийн ажлыг гүйцэтгэгч нь цэцэрлэгчийн сертификаттай байх.



Зураг 6.6 Мод, сөөгийг хэлбэржүүлэх

5.10 МОД, СӨӨГИЙГ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХАД АШИГЛАГДАХ БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалт, хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааны ерөнхий заавар оруулав.

Мод, сөөгийг шилжүүлэн суулгахдаа MNS 6773:2019 Сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах техникийн шаардлага, MNS 6774:2019 Том мод суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах стандартыг мөрдөнө.

6.10 Мод, бут сөөгийн шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Суулгацыг 	Их хэмжээний мод, сөөгийг эгнүүлэн суулгахад зориулагдсан техник.	➤ Үндсэн трактортой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан байна. ➤ Тракторт холбох хөдөлгүүр тус бүр дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө. ➤ Хөдөлгүүр тус бүрийн тохиргоо, ажлын дарааллыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дагаж мөрдөнө. ➤ Жижиг трактор жолоодогч нь жолоодох эрх бүхий ангилалтай үнэмлэхтэй байна. ➤ Тракторын жолооч нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж
Шилжүүлэн суулгагч 	Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад зориулагдсан. Дунд зэргийн өндөртэй мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдана.	


Шилжүүлэн суулгагч 	Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад зориулагдсан дунд оврын ачаатай шилжүүлэн суулгагч. Том хэмжээний мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдана.	доргилтын хамгаалалттай бүс, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэглэлтэй байна.
Шилжүүлэн суулгагч 	Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад зориулагдсан том оврын ачаатай шилжүүлэн суулгагч. Ногоон байгууламжийн түүхэн, ховор мод, сөөгийг шилжүүлэн суулгах, зөөвөрлөхөд ашиглагдана.	
Өргөгч машин 	Мод сөөгийг өргөж, ачиж буулгах зориулалттай машин.	➤ Үндсэн трактортой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан байна. ➤ Тракторт холбох хөдөлгүүр тус бүр дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө.
Өргөгч кран 	Том модыг өргөх, шилжүүлэн тарихад ашиглагдана.	➤ Хөдөлгүүр тус бүрийн тохиргоо, ажлын дарааллыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дагаж мөрдөнө. ➤ Жижиг трактор жолоодогч нь жолоодох эрх бүхий ангилалтай үнэмлэхтэй байна. ➤ Тракторын жолооч нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж доргилтын хамгаалалттай бүс, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэглэлтэй байна.
Титэм баглагч 	Том модыг шилжүүлэх, зөөж тээвэрлэхэд модны титмийн хэсгийг боож, баглах зориулалттай машин.	

5.11 НОГООН БАЙГУУЛАМЖ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТЭД АШИГЛАГДАХ УСАЛГААНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД, МАШИН МЕХАНИЗМ

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалт, хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааны ерөнхий заавар оруулав.

Мод, сөөгийг шилжүүлэн суулгахдаа MNS 6773:2019 Сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах техникийн шаардлага, MNS 6774:2019 Том мод суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах стандартыг мөрдөнө.

6.11 Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Дуслын усалгааны систем 	Мод, сөөгт зориулсан дуслын усалгааны систем бөгөөд усны хэрэгцээг хангах зорилгоор хэрэглэдэг. Мод, сөөгийн өсөлт хөгжилд ус маш чухал бөгөөд тухайн ургамалд ус чийгийг өгөх, ус зарцуулалт бага байх усалгааны төрлийг сонгох хэрэгтэй.	➤ Ажилтан нь тухайн орчинд тохирсон хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна.
Бороожуулагч 	Зүлгийн усалгаанд зориулагдсан төхөөрөмж.	➤ Ажиллуулахын өмнө хэвийн ажиллагааг шалгана. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна
бага оврын бороожуулагч 	Бага хэмжээний зүлгийн талбайд хэрэглэж болно	➤ Ажиллуулахын өмнө хэвийн ажиллагааг шалгана. ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна

Усны нөөцлийн сав 	Зүлэгжүүлсэн талбайг услах усыг нөөцлөх зориулалтаар ашиглана.	➤ Бүрэн бүтэн байлгаж ашиглана.
Гар шүршүүр 	Крантны ус, даралттай усны үүсвэрт холбож, зүлэг, цэцэг тарих талбайг услах зорилгоор ашиглана.	➤ Шүршүүрийн хэрэглэхэд бэлэн эсэхийг шалгана. ➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна.
Цахигаан мотор ба гар насос 	Хувин саваар ус зөөж зүлэг цэцэг улсах ажлыг хөнгөвчлөхийн тулд худаг, голоос ус сорж, татах зорилгоор зөөврийн цахилгаан мотор эсвэл ус сорж татах насос зэргийг ашигладаг.	➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна.
Услуур (шүршүүр) 	Цэцгийн мандал, цэцгийн үрэслэгээ услах зориулалттай. Цэцэг болон хүлэмжинд таригдсан үр, үрслэгийг шүршиж услахад тусгай цоргот шүршүүртэй, төмөр буюу нийлэг эдээр хийгдсэн хувинг хэрэглэнэ.	➤ Хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангагдсан байна. ➤ Ашиглалтын өмнө бүтэн байдлыг шалгана.
Зөөврийн мотор 	Мод, сөөгийн усалгааг зөөврийн аргаар услахад ашиглагдана.	➤ Усалгааны машинтай ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан байна. ➤ Зөөврийн моторт холбох хөдөлгүүр тус бүр дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө.
Усалгааны машин	Ногоон байгууламжийн мод, сөөгийг зөөврийн аргаар услахад зориулагдсан.	➤ Усалгааны машин жолоодогч нь жолоодох эрх бүхий ангилалтай үнэмлэхтэй байна.

		
---	--	--


5.12 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ӨВЧИН, ХОРТОНТОЙ ТЭМЦЭХЭД АШИГЛАГДАХ БАГАЖ, ХЭРЭГСЭЛ

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд мод, сөөгийг өвчин хортонтой тэмцэхэд ашиглагддаг багаж, хэрэгслийн зориулалт, ашиглалт, хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааны ерөнхий заавар оруулав.

Өвчин, хортонтой тэмцэхдээ MNS: 6763.2019 Шавж наалдуулагч цаасан урхи хэрэглэх аргын дагуу мөрдөнө.

6.12 Ногоон байгууламжийн өвчин хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
Хор цацагч 	Хортон шавж устгах, хог ургамлын тархалтыг бууруулах зориулалттай. Мөр хоорондын боловсруулалтын, үр ариутгагч, үйлчлэлээр нь хуурай байдлаар пургих, шингэн байдлаар шүрших, хагас хуурай байдлаар үрийн гадаргууд наалдуулах зэргээр ашиглана.	➤ Химийн хорт бодис хэрэглэх, эрдэс бордоогоор хөрсийг бордоход 18 нас хүрээгүй хүүхэд, жирэмсэн ба хөхүүл хүүхэдтэй эхчүүд, эмнэлгийн үзлэгээр хорт бодистой ажиллахыг зөвшөөрөөгүй хүмүүсээр ажил гүйцэтгүүлэхийг хориглоно. ➤ Химийн бодис эсвэл байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг ашиглан хортон шавж, мэрэгчидтэй тэмцэх, хяналт тавьж зохих арга хэрэглэх талаар сургалтад хамрагдсан байна. ➤ Өдөр дунд их нартай халуун үед химийн бодис ууршдаг учраас шүршилтийг цаг агаар тогтуун үеэр буюу өглөө, оройн цагаар хийх нь хамгийн тохиромжтой. ➤ Ургамал хамгаалах бодис найруулах, шүршиж хэрэглэх үед аюулгүй ажиллагааны дүрэм баримтлан хувийн хамгаалах хэрэгслийг зөв, бүрэн өмссөн байна.

Үүрдэг хор цацагч 	Ургамал хамгаалах бодис шүрших зориулалтаар ашиглана. Бага хэмжээний талбайн цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжид хэрэглэдэг. Талбайн бүх хэсгүүдэд цацах даралт, шингэний найрлага, цацах норм жигд, ижил байх ёстой. Ингэж жигд цацахад алхалтын хурд хамгийн их нөлөөлнө гэдгийг анхаарах хэрэгтэй.	➤ Химийн хорт бодис хэрэглэх, эрдэс бордоогоор хөрсийг бордоход 18 нас хүрээгүй хүүхэд, жирэмсэн ба хөхүүл хүүхэдтэй эхчүүд, эмнэлгийн үзлэгээр хорт бодистой ажиллахыг зөвшөөрөөгүй хүмүүсээр ажил гүйцэтгүүлэхийг хориглоно. ➤ Ажлын байранд хордсон хүмүүст эмнэлгийн яаралтай түргэн тусламж үзүүлэх явуулын аптек байрлуулсан байх шаардлагатай. ➤ Хувийн хамгааллын хувцас хэрэгслийг тогтмол хугацаанд шалгаж, шаардлагатай бол шинэчилж, солих арга хэмжээ авна.
Үүрдэг хор цацагч 	Даралтат сав бүхий цацах төхөөрөмж. Таримлын төрөл болон өндрөөс хамаарч ургамал хамгааллын бодисыг янз бүрийн нормоор цацах шаардлагатай.	➤ Тодорхой хугацаанд өлгөнө. ➤ Нисдэг бүх төрлийн шавж наалдаж өртдөг тул болгоомжтой хэрэглэх, ашигтай зүйл өртөхөөс сэргийлэх ➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна.
Шавж наалдуулагч цавуутай наалт 	Шавжийг өөртөө татан наалдуулах замаар хортон шавжтай тэмцэх зориулалтаар ашигладаг. Шавжийн тооны хэт олшрол явагдаж байгааг тогтоосны дараа тэмцэх аргыг явуулна. Шавжийг өнгөөр даллан дуудаж урхидахад зориулагдсан. Хоёр талдаа эсвэл нэг талдаа наалдуулах цавуутай. Хортон шавжийн гаралт, нягтшил, тооны хөдлөл зүйг хянах, тоо толгойг устгахад хэрэглэнэ.	➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна. ➤ Байгалийн олон төрөл зүйл өртдөг тул болгоомжтой хэрэглэх шаардлагатай.
Шавж баригч төхөөрөмж 	Шавжийн дуртай гэрлийг ашиглан шавжийг өөртөө татаж барих зарчмаар ажилладаг төхөөрөмж юм. Шавжийн ид нисэлтийн үед хэрэглэх ба байнга хэрэглэх нь зохимжгүй.	➤ Хамгаалах хэрэгсэл өмссөн байна. ➤ Байгалийн олон төрөл зүйл өртдөг тул болгоомжтой хэрэглэх шаардлагатай.

6. ЦЭЦЭРЛЭГЧИЙН БАГАЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШААРДЛАГА

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, албан байгууллагын хөрс боловсруулах, зүлэгжүүлэх, мод, сөөг суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжийн шалгуур үзүүлэлт (хүснэгт 5.1) -ийн шаардлагыг хангаж буйг хянаж шалгана.

Хүснэгт 6.1 Цэцэрлэгчийн багаж тоног төхөөрөмжийн шаардлага

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл бүрэн хангагддаг эсэх	☐	☐
2	Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд байгаа эсэх	☐	☐
3	Зүлэгжүүлэлтийн ажилд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүд байгаа эсэх	☐	☐
4	Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл байгаа эсэх	☐	☐
5	Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд байгаа эсэх	☐	☐
6	Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд байгаа эсэх	☐	☐
7	Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд байгаа эсэх	☐	☐
8	Мод, сөөгийн хэлбэржүүлэлтэнд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд байгаа эсэх	☐	☐
9	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм байгаа эсэх	☐	☐
10	Ногоон байгууламжийн өвчин, хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл байгаа эсэх	☐	☐

Тайлбар: Шаардлага хангасан бол **“Тийм”** шаардлага хангаагүй бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

1. “Ойд арчилгаа хийх тухай” Улаанбаатар 2012 он
2. “Ойн мэргэжлийн ажилтан” гарын авлага
3. Нинж .Б. “Жимсний аж ахуйн дадлага” 2014 он
4. Нинж Б.” Жимс, жимсгэнэ тариалалт боловсруулалт” гарын авлага 2015 он
5. Нинж Б. “Цэцэрлэгжүүлэлт, цэцгийн аж ахуйн дадлага”, Улаанбаатар 2012
6. Цогтоо Я., Банзрагч ц., Ганбаатар Ч., “Ойн аж ахуйн механикжсан технологи”, Улаанбаатар 2014 он
7. Forestry suppliers, CATALOG-67, 2016
8. Ургамал хамгаалах цогц арга, ургамал хамгааллын бодисын хэрэглээ-2019
9. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа
10. MNS 6139:2010 Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
11. MNS 6141:2010 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
12. MNS 2418:2011 Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах, Ерөнхий шаардлага
13. MNS 6253-1:2011 Мод сөөгийн үрийг тарихад бэлтгэх, Ерөнхий шаардлага
14. MNS 6253-2:2011 Мод сөөгийн үр тарих Ерөнхий шаардлага
15. MNS 6253:2011 Мод сөөгийн үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага
16. MNS 6254:2011 Мод сөөгийн суулгацыг бойжуулах, Ерөнхий шаардлага
17. MNS 6256:2011 Сөөгөнцрийн суулгац. Ерөнхий шаардлага
18. MNS 6257:2011 Улиасны суулгац. Ерөнхий шаардлага
19. MNS 6258-1:2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага
20. MNS 6258-2:2011 Мод сөөгийн суулгац арчлах
21. MNS 6259:2011 Ганц наст цэцэг тарих арга
22. MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
23. MNS 6772:2019 Мод сөөгийг хэлбэржүүлэх. Техникийн шаардлага
24. MNS 6773:2019 Сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах Техникийн шаардлага
25. MNS 6774:2019 Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах
26. GB/T 6866—2008 (БНХАУ-ын стандарт)
27. GB 6866 — 86 (БНХАУ-ын стандарт)
28. MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага
29. MNS 5622-2006 Гарын хамгаалалт /бээлий/

- 30. MNS 5623-2006 Хөлийн хамгаалалт ажлын тусгай гутал
- 31. MNS 5621-2006 Толгой хамгаалах хэрэгсэл дуулга
- 32. MNS 4931-2000 Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага
- 33. MNS 13688-2000 Ажлын тусгай хувцас ерөнхий шаардлага
- 34. <https://estandard.gov.mn/>
- 35. <https://mofa.gov.mn/exp/>
- 36. <https://www.mlsp.gov.mn/>
- 37. <https://www.doczhi.com/p-380848.html>



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



70118060



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар